

# МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

## 2013 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2013.07.10

Улаанбаатар хот

Комисс хуульд заасны дагуу Монгол Улс дахь хүний эрхтэй холбоотой аливаа асуудлаар судалгаа, хяналт шалгалт явуулж, санал гаргах; хүний эрх зөрчсөн тухай гомдлыг хүлээн авч, шалгаж, шийдвэрлэх; хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих; олон улсын хүний эрхийн гэрээг соёрхон батлах, нэгдэн орох, хэрэгжүүлэх явдлыг дэмжих хүрээнд 2013 оны хагас жилд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

### НЭГ. ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ САХИН ХАМГААЛАХ, БОДЛОГО ТОДОРХОЙЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД

#### 1.1 Судалгаа, дүн шинжилгээ

*1.1.1 Ялтан эмэгтэйчүүдийн хүүхдэд асран хамгаалагч томилохтой холбоотой шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх*

Комисс уг судалгааны хүрээнд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 188 дугаар зүйл, Гэр бүлийн тухай хуулийн 25, 63, 66, 71 дүгээр зүйлүүдэд дүн шинжилгээ хийлээ. Түүнчлэн хорих 407 дугаар ангид ял эдэлж буй эмэгтэйчүүдэд ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолд хүний эрхийн үүднээс судалгаа, дүн шинжилгээ хийхээр төлөвлөн ажиллаж байна.

*1.1.2 Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх ажлыг эцэслэж, судалгааг хэвлэлтэд бэлтгэх*

Энэхүү судалгааны зорилго нь мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэргийн бүрэлдэхүүн, гэм буруутай хүнд оногдуулах ял шийтгэлийн өнөөгийн бодит нөхцөл, байдлыг шүүхийн практикт тулгуурлан, олон улсын хүний эрхийн гэрээ, конвенц, барим бичигтэй харьцуулан дүн шинжилгээ хийж судалгааны дүнг гарган холбогдох байгууллагуудад санал зөвлөмж хүргүүлэх, гэмт хэргийн тухай хуулийн төсөлд тусгуулахад оршиж байгаа бөгөөд Хүний эрхийн Үндэсний Комисс, Нийслэлийн шүүх, Хүний аюулгүй байдлын судалгааны төвийн ажилтнуудаас бүрдсэн судалгааны баг удирдамжийн дагуу судалгааны ажлыг хамтран гүйцэтгэж, хэвлэлтэд шилжүүлэхэд бэлэн болоод байна.

*1.1.3 ОУХБ-ын төслөөр хийгдэх шалгалт, судалгааны ажлын удирдамжийг батлуулж, гэрээ байгуулан, төслийг хэрэгжүүлэх*

Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын дэмжлэгээр хорих анги болон цэргийн ангид албадан хөдөлмөрийн асуудлаар мониторинг хийх төслийн хүрээнд тусгай удирдамж боловсруулж, төслийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн уг мониторингийн хүрээнд хорих анги, цэргийн ангиудаас авах судалгааны санал асуулгыг Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран боловсруулсан болно.

Төслийн хүрээнд сонгон авсан 3 хорих анги, 2 цэргийн ангид албадан хөдөлмөрийн асуудлаар 2013 оны 6-8 дугаар саруудад мониторинг хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлох зорилготой. Комисс Баянхонгор аймаг дахь барилгын цэргийн 339 дүгээр анги, Баянзүрх дүүрэг дэх эмэгтэйчүүдийн хорих 407 дугаар анги, Төв аймгийн Мөнгөнморьт сум дахь хорих 417 дугаар анги, Амгалан дахь хорих 421 дүгээр ангиудад тус тус хяналт шалгалт, мониторингийн ажлыг зохион байгуулаад байна. Түүнчлэн 8 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд Баян-Өлгий аймаг дахь барилгын цэргийн 340 дүгээр ангид ажиллахаар төлөвлөж байна.

Уг хяналт шалгалт, мониторингийн ажлын дүнг 11 дүгээр сард танилцуулах бөгөөд Зэвсэгт хүчний жанжин штаб, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын удирдлагуудыг байлцуулан дүнгийн хурал хийх болно.

#### *1.1.5 Хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх*

2013 оны 5 сарын 31-ний өдөр "Хүний эрхийн боловсролын талаарх өнөөгийн байдал" сэдэвт уулзалтыг иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийн дунд зохион байгуулсан ба хүний эрхийн боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Бүх нийт боловсролын төлөө" эвсэл, Монголын Эмнести Интернэшнл зэрэг төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон болно. Уулзалтын үеэр хүний эрхийн боловсролын чиглэлээр ажиллаж байгаа туршлага судлах, зураглал гаргах, өнөөгийн нөхцөл байдлаа үнэлэх шаардлагатайг онцолсон байна. Мөн ажлын хүрээнд Боловсрол шинжлэх ухааны яамтай хамтран 6 сарын 18, 19-ний өдөр "Хүний эрхийн боловсрол: Ерөнхий боловсролын сургуульд" хэлэлцүүлэг-сургалтыг Фаурд группын дэмжлэгтэйгээр зохион явуулсан ба энэхүү хэлэлцүүлэг сургалтад хүний эрх, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагуудын төлөөлөл болон багшлах боловсон хүчин бэлтгэдэг их дээд сургуулиуд, ерөнхий боловсрол олгох сургуулиудын багш нар урилгаар оролцож санал бодлоо солилцож, "Хүний эрхийн төлөөх залуус" сэдэвт сургалтад хамрагдсан юм.

Хүн бүрт хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх, хүний эрх, эрх чөлөөний талаар мэдлэг ойлголтыг олгох нь хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, хүнлэг энэрэнгүй, ардчилсан нийгмийн нэн тэргүүний асуудал болоод байна. Тиймээс ерөнхий боловсролын сургуульд хүний эрхийн боловсролыг хөтөлбөрийг нэвтрүүлэх, сургалтын төлөвлөгөө, заах арга зүй, хичээлийн бус нэмэлт хөтөлбөрт интеграцичлах боломжийг хэлэлцэж, сургуулийн удирдлага, багш нарыг чадавхжуулах, хүний эрхийн боловсрол олгох, хүүхэд залуучуудын үүсгэл

санаачлагыг дэмжих чиглэлээр боловсролын байгууллага, сургуулиуд, төрийн ба төрийн бус байгууллагуудын хооронд хамтын ажиллагааг тодорхойлж, цаашид энэ чиглэлээр хамтран ажиллахаар боллоо.

## **1.2 Хяналт, шалгалт**

### *1.2.1 Төвлөрсөн хорих анги болон аймгуудын цагдан хорих төвд шалгалт хийх*

- *Авдрант дахь чанга дэглэмтэй 403 дугаар хорих ангид шалгалт хийсэн тухай*

Хүний эрхийн Үндэсний Комисс, Хууль зүйн яам, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий газартай хамтран 2013 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр Төв аймгийн Лүн сумын нутагт байрлах ШШГЕГ-ын хорих 403 дугаар ангид тусгай удирдамжийн дагуу хяналт шалгалт хийв.

Хамтарсан шалгалтын үр дүнд “Авдрантын” буюу 403 дугаар хорих ангид ял эдэлж буй хүмүүсийн Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө хангагдаж байгаа эсэх, хорих байрны ахуй нөхцөл, эргэлт, уулзалтын байр, эмнэлгийн үйлчилгээний хүртээмж, хүнсний хангамж, хорих байгууллагын ажилтнуудын зан харилцаа, ялтны хувийн хэргийн бүртгэлийн байдал зэрэг нь хүний эрхийн үндсэн зарчимд хэрхэн нийцэж буйг үзэж танилцан зарим асуудлыг газар дээр нь шийдвэрлэж, эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүсийн хуульд заасан эрхийг баталгаатай хангуулах талаар тодорхой арга хэмжээ авахуулж хамтран ажиллахаар боллоо.

- *Цагдан хорих 0461 дүгээр ангийн нөхцөл байдалтай танилцсан талаар*

Улсын Ерөнхий прокурорын газар, Хууль зүйн яам, Монголын өмгөөлөгчдийн холбооны төлөөллийг оролцуулан 5 дугаар сарын 16-ны өдөр цагдан хорих 0461 дүгээр анги дээр ажиллалаа. Ажлын хүрээнд сэжигтэн, яллагдагчийн өмгөөлөгчөөр хангагдах эрх, эрх зүйн туслалцаа авах эрхийн асуудлыг шалгаж, цагдан хорих байрны ахуй нөхцөл, барилга байгууламжийн нөхцөл байдалтай танилцлаа.

### *1.2.2 “Нарантуул” олон улсын худалдааны төвд гомдол, мэдээллийн дагуу хяналт шалгалт хийв.*

Комисс гомдол мэдээллийн дагуу 2013 оны 3 дугаар сарын 20-ны өдөр тус захад хяналт шалгалтын ажил зохион байгуулсан бөгөөд гомдол мэдээлэл болон хавсаргасан баримт бичиг, хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдлыг үндэслэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасныг удирдлага болгон дараах шаардлагыг хүргүүлсэн болно.

Хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдлаас үзвэл Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.3 дахь хэсэгт “Түрээсийн гэрээг бичгээр байгуулах бөгөөд үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх гэрээг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлнэ.” гэж заасан атал тус худалдааны төвд задгай талбай дээр лангуу түрээсэлж буй иргэдтэй хуульд заасан шаардлагад нийцүүлж гэрээ хэлцэл байгуулахгүй байгаа нь зарим зөрчил гарах нөхцлийг бүрдүүлж байсан бөгөөд түрээсийн гэрээг ийнхүү хуульд заасан шаардлагад нийцүүлэн бичгээр байгуулахгүй байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4-т заасан Монгол Улсын иргэний “хувийн аж ахуй эрхлэх” эрхийг хөндөж байгаа тул худалдааны төвд лангуу түрээсэлж буй худалдаа эрхлэгч иргэдийн Үндсэн хууль, хуулиар баталгаажсан эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүднээс түрээсийн гэрээ байгуулаагүй худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэдтэй түрээсийн гэрээг бичгээр байгуулах шаардлагыг хүргүүлсэн болно.

### *1.2.3 Орчны хүртээмжтэй, аюулгүй байдлын талаарх үндэсний стандартын хэрэгжилтийг шалгах*

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн заалт, Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хамтран Улаанбаатар хотод шинээр баригдаж буй иргэний барилга байгууламжууд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцид заасан тусгай хэрэгцээ, шаардлагад нийцэж буй эсэхийг үнэлж, тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн холбогдох байгууллагуудад санал, зөвлөмж гаргаж, хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2013 оны 6 дугаар сарын 4-нөөс 25-ны өдрүүдэд хяналт шалгалт хийлээ.

Энэ шалгалтын хүрээнд нийслэлд баригдаж буй 17 давхраас дээш 11 барилга, 17 давхраас доош 11 барилга байгууламжид Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, техникийн шаардлага MNS 5682:2006; Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056:2009; Иргэний барилга төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин, үндсэн шаардлага MNS 6055:2009 стандартуудын хэрэгжилт хэрхэн хангагдаж байгааг шалгасан болно.

Хяналт шалгалтын ажлын илтгэх хуудсыг боловсруулан 2013 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлээд байна.

### *1.2.4 Барилгын салбар дахь хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд хийх шалгалтын бэлтгэл хангах*

Барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаандаа Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэрхэн мөрдөж ажиллаж буйг шалгаж, ажилчдын хөдөлмөрлөх эрхийн талаарх хуульд заасан эрхийг баталгаатай

хангуулах талаар холбогдох байгууллагуудад санал, зөвлөмж хүргүүлэх, тодорхой арга хэмжээ авахуулах, хамтран ажиллах зорилгоор энэхүү хяналт шалгалтыг зохион байгуулахаар төлөвлөж буй бөгөөд Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоотой харилцаж, хяналт шалгалтын ажлын удирдамжийг хамтран баталлаа.

Хяналт шалгалтын хүрээнд сонгон авсан 5 барилгын компани дээр хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахаар төлөвлөж, уг хяналт шалгалтыг барилгын ажлын үйл ажиллагаа идэвхтэй явагддаг 8-9 дүгээр саруудад хийхээр төлөвлөж байна.

### **1.3 Хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, тогтолцоог боловсронгуй болгоход чиглэсэн бусад арга хэмжээ**

#### *1.3.1 Хохирол нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх*

Шүүхийн практикт гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэхдээ зөвхөн нотлох баримтад тулгуурлаж байгаа тул эмчилгээний зардал, оршуулгын зардал, тээврийн зардлын баримт, түүнчлэн аймаг, дүүргийн засаг даргын тамгын газрын санхүүгийн хэлтсийн үнэлгээний комиссын үнэлгээ зэргийг харгалзан хохирлыг тогтоож, нөхөн төлүүлэх шийдвэрийг гаргаж байна. Өөрөөр хэлбэл энэхүү зардалд эд хөрөнгийн хохирол хамаарах бөгөөд эдийн бус хохирол тооцогдохгүй орхигддог. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлийн 42.3.9 дэх хэсэгт заасны дагуу хохирогч нь гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй байдаг. Гэтэл хохирогч энэхүү эрхээ эдэлж чадахгүй байгаа нь эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгааг илтгэж байна.

Комиссын Ажлын алба эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, олон улсын болон гадаад улс орны эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэх шаардлага зүй ёсоор урган гарч байгааг үндэслэн дэлхийн бусад улсад энэ төрлийн хохирлыг хэрхэн нөхөн төлж байгаа практикт судалгаа хийж Хууль зүйн яаманд саналын хамт хүргүүлээд байна.

#### *1.3.2 Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах*

Хууль зүйн яамны боловсруулж буй Гэмт хэргийн тухай хуулийн төсөл, Зөрчлийн тухай хуулийн төслүүдэд хүүхдийг хүчирхийллээс хамгаалах эрх зүйн зохицуулалтыг оруулах саналыг гаргаж, уг санал төслүүдэд тусгагдсан болно.

#### *1.3.3 НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколд нэгдэж ороход нөлөөлөх үйл ажиллагааг үргэлжлүүлэх*

Комисс уг нэмэлт протоколд нэгдэн орохтой холбогдуулан хуулийн төсөл боловсруулж Хууль зүйн яаманд хүргүүлсэн бөгөөд уг төсөлд урьдчилан сэргийлэх

үндэсний механизмын чиг үүргийг Хүний эрхийн Үндэсний Комисст хариуцуулахаар тусгасан ба үүнтэй холбоотой Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг давхар боловсруулаад байна.

Түүнчлэн “Хүний эрх” сэтгүүлийн 2013 оны 1 дүгээр дугаарыг эрүүдэн шүүхтэй холбоотой асуудлаар дагнан бэлтгэж, гадаад, дотоодын судлаач, эрдэмтдийн өгүүлэл, нийтлэлээс бүрдүүлсэн бөгөөд уг сэтгүүлийг Хууль зүйн яам, УИХ зэрэг байгууллагуудад тараан нөлөөллийн үйл ажиллагаа явуулсан болно.

#### *1.3.4 Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 3 дугаар нэмэлт протоколд нэгдэн орох чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаа явуулах*

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей 2011 оны 12 дугаар сарын 19-ний өдөр Харилцаа холбооны журмын талаарх Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 3 дугаар нэмэлт протоколыг баталсан ба хүүхдийн эрхийн зөрчлийн талаар хүүхэд өөрөө буюу түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигч гомдол гаргах эрхтэй болсон юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн улсууд тус баримт бичигт гарын үсэг зурах, соёрхон батлах нь 2012 оны 2 дугаар сарын 28-ны өдрөөс эхэлж нээлттэй болсон. Тус протоколыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын арван гишүүн улс соёрхон баталснаар хүчин төгөлдөр болох юм.

Монгол Улсын зүгээс Хүүхдийн эрхийн тухай конвенцийн гуравдугаар нэмэлт протоколыг соёрхон баталснаар уг протоколд дурдсанаас бусад нэмэлт үүрэг хүлээхгүй ба Хүүхдийн эрхийн тухай конвенцоор хүлээсэн үүрэг болох хүүхдийн эрхийг хүндэтгэх, хамгаалах арга хэмжээг бүрэн дүүрэн, цогцоор нь шийдвэрлэх боломжтойг онцлон 3 дугаар нэмэлт протоколд нэгдэн орох явдлыг Хүний эрхийн Үндэсний Комиссын зүгээс бүрэн дэмжиж байгааг илэрхийлсэн албан тоотуудыг Комиссын дарга Монгол Улсын Ерөнхий сайд, Гадаад харилцааны сайд, Хууль зүйн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, УИХ-ын Хүний эрхийн дэд хороонд 2013 оны 02 дугаар сарын 26-ны өдөр тус тус хүргүүллээ.

Түүнчлэн НҮБ-ын Хүүхдийн сан, Гадаад харилцааны яам, Хүүхдийн төлөө үндэсний газар, бусад иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг байлцуулан зөвлөлдөх уулзалт зохион байгуулж нэмэлт протоколд нэгдэн орох асуудлаар хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт саналаа хүргүүлэхээр шийдвэрлэсэн болно.

#### *1.3.5 Хууль тогтоомжийн төсөлд хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ хийх*

Хууль зүйн яамнаас санаачлан боловсруулж буй Маршалын албаны тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Цагдаагийн албаны тухай, Хууль сахиулагчийн

эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдэд хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ хийж, санал боловсруулан хүргүүлэв.

Унаач хүүхдийн эрхтэй холбоотойгоор Үндэсний их баяр наадмын тухай хууль, Үндэсний их баяр наадмын морин уралдааны дүрэм зэрэгт дүн шинжилгээ хийж Хууль зүйн сайд Х.Тэмүүжинд эрх зүйн шаардлагатай зохицуулалтын талаарх саналыг 03 дугаар сарын 29-ны өдөр, Хүүхдийн төлөө үндэсний газар, Морин спорт уяачдын холбоонд 03 дугаар сарын 30-ны өдөр тус тус шаардлага хүргүүлээ.

Түүнчлэн Улсын Их хурлын эмэгтэй гишүүдийн төлөөлөлтэй Комисс дээр уулзаж, хуулийн төсөл болосвруулах ажлын хэсгийг Соёл, спорт, аялал жуулчлалын яам дээр байгуулахаар тохиролцсон бөгөөд тус яамны зүгээс Комиссын төлөөллийг ажлын хэсэгт оруулахаар тохиролцсон болно.

#### **1.4 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл боловсруулах**

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь удаагийн илтгэлийг Уул уурхай ба хүний эрх, хүүхдийн зарим эрхийн асуудал, Монгол Улс дахь ЛГБТ хүмүүсийн хүний эрхийн нөхцөл байдал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн байгууллагуудаас Монгол Улсад өгсөн зөвлөмжийн хэрэгжилт сэдвийн хүрээнд бичиж 2013 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороотой хамтран 2013 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Төрийн ордонд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь удаагийн илтгэлийг олон нийтэд нээлттэй хэлэлцүүлсэн. Хэлэлцүүлэгт төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд, олон улсын байгууллагуудын төлөөлөл 80 хүн оролцож өөрсдийн санал бодлоо илэрхийлсэн.

Тус илтгэлийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2013 оны 4 дүгээр сарын 24, 2013 оны 5 дугаар сарын 22 -ны өдрүүдийн хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд 2013 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь удаагийн илтгэлтийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 13 тоот тогтоол гарсан.

#### **1.5 Хүний эрх зөрчсөн тухай гомдлыг хүлээн авч, шалгаж шийдвэрлэх**

##### *1.4.1 Гомдлыг шалгаж шийдвэрлэх үйл ажиллагааг үргэлжлүүлэх*

2013 оны 6 дугаар сарын 30-ний өдрийн байдлаар Комисст нийт 396 гомдол ирсэн бөгөөд хуулийн хугацаанд шалгаж, шийдвэрлэх ажиллагааг хийж байна. Цахим гомдлын системийг бий болгосноос хойш нийт 18 гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн болно.

Гомдол	Ирүүлсэн	396
	Шийдвэрлэсэн/шилжүүлсэн	377
	Ажиллагаанд байгаа	19

Мөн хугацаанд 124 хүнд 55 цаг 30 минутын хууль зүйн зөвлөгөө өгсөн байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос дөрвөн оронтой утасны дугаар олголтыг түр хугацаагаар түдгэлзүүлээд байгаа тул тусгай утас суурилуулах ажил хүлээгдэж байна.

2013 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар Комиссын гишүүний нийт 27 шаардлага, зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсний 15 нь шаардлага, 12 нь зөвлөмж байна. Эдгээрийн 13 нь хяналт, шалгалтын хүрээнд, 13 нь гомдлын дагуу, 1 судалгаа, мониторингийн хүрээнд хүргүүлжээ.

Комиссын гишүүдийн гаргасан шаардлага, зөвлөмжийг үйл ажиллагааны чиглэлээр ангилбал:

Үйл ажиллагааны чиглэл		2012 он	2013 он
Шаардлага	Хяналт, шалгалтын хүрээнд	4	2
	Гомдлын дагуу	10	12
	Бодлого, дүн шинжилгээний хүрээнд	-	-
	Судалгаа, мониторингийн хүрээнд	-	1
<b>Нийт шаардлага</b>		<b>14</b>	<b>15</b>
Зөвлөмж	Хяналт, шалгалтын хүрээнд	4	10
	Гомдлын дагуу	1	2
	Бодлого, дүн шинжилгээний хүрээнд	1	-
	Судалгаа, мониторингийн хүрээнд	-	-
<b>Нийт зөвлөмж</b>		<b>6</b>	<b>12</b>
Шаардлага, зөвлөмж	Хяналт шалгалтын хүрээнд	8	13
	Гомдлын дагуу	11	13
	Бодлого, дүн шинжилгээний хүрээнд	1	
	Судалгаа, мониторингийн хүрээнд	-	1
<b>Нийт шаардлага, зөвлөмж</b>		<b>20</b>	<b>27</b>

Судалгаа мониторингийн хүрээнд 3/07 дугаартай 1 шаардлага хүргүүлсэн байна.

2013 оны эхний хагас жилд гаргасан Комиссын гишүүдийн шаардлага, зөвлөмжийг өмнөх жилтэй харьцуулан үзвэл 35 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2. Шаардлага, зөвлөмжийг бичсэн субъектээр ангилбал:

	Шаардлага	Зөвлөмж
--	-----------	---------



Ж.Бямбадорж	Хяналт, шалгалтын хүрээнд	1	4
	Гомдлын дагуу	2	
Н.Ганбаяр	Хяналт, шалгалтын хүрээнд		
	Гомдлын дагуу	3	2
П.Оюунчимэг	Хяналт, шалгалтын хүрээнд	2	4
	Гомдлын дагуу	4	
	Судалгаа мониторингийн хүрээнд	1	
Ж.Дашдорж	Хяналт, шалгалтын хүрээнд		2
	Гомдлын дагуу	1	
<b>Нийт 27 шаардлага, зөвлөмж гаргаснаас</b>		<b>15</b>	<b>12</b>

#### 1.4.2 Гомдлын дагуу төлөөлөн нэхэмжлэл гаргах үйл ажиллагааг үргэлжлүүлэх

- Комиссын гишүүн П.Оюунчимэг иргэн Д.Энхмандахыг төлөөлөн Хөвсгөл аймгийн сум дундын шүүхэд хууль бусаар эрүүгийн хэрэгт шалгагдсаны улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэх тухай асуудлаар 251,611,363 төгрөг нэхэмжилсэн бөгөөд шүүхээс Засгийн газрын нөөц сангаас 64,874,400 төгрөгийг гаргуулж Д.Энхмандахад олгохоор шийдвэрлэсэн болно.
- Хүчин төгөлдөр бус шийтгэх тогтоолоор иргэн Д.Болдыг илүү хугацаагаар, чанга дэглэмтэй хорих ангид ял эдлүүлсэн асуудлаар Баянгол дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж, 32,057,500 төгрөг нэхэмжилсэнээс шүүх Засгийн газрын нөөц сангаас 22,070,000 төгрөгийг гаргуулж Д.Болдод олгохоор шийдвэрлэсэн болно.

#### 1.4.3 Гомдлыг цахим хэлбэрээр хүлээн авах боломжийг судлах

Гомдлыг цахим хэлбэрээр хүлээж авах боломжийг Комиссын вэб сайт дээр бий болгож, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн болно.

#### 1.4.4. Гомдол, хяналт, шалгалт, шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, бүртгэл, мэдээллийн санг боловсронгуй болгох

Комиссын 2001 оноос хойш шүүхэд гаргасан нэхэмжлэлийн бүртгэлийг цахим санд орууллаа. Ингэснээр цахим мэдээллийн сан гомдол, шаардлага, зөвлөмж, төлөөлөн нэхэмжлэл, хяналт шалгалт гэсэн 4 бүтэцтэй, бүртгэлийг хэлтсийн ажилтнууд цаг тухай бүр бүртгэж байна.

## ХОЁР. ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ, ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.1 Тодорхой бүлэгт чиглэсэн хүний эрхийн сургалт:

#### 2.1.1 “Хүний эрхэд суурилсан хандлага” сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулах

Хүний эрхийг хөхиүлэн дэмжих бүрэн эрхийнхээ хүрээнд иргэд, төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн бүх байгууллага, олон нийтэд хүний эрхийн боловсрол олгох, хүний эрхийн соёлыг төлөвшүүлэх зорилгоор 9 сэдвийн хүрээнд 49 удаагийн нийт 193 цагийн сургалтыг 1895 оролцогчтойгоор зохион байгуулсан байна. Үүнээс:

Хүний эрхийн сургалт	Цаг	Оролцогч
<i>Төлөвлөгөөт сургалт (Нээлттэй өдрийг багтаасан)</i>	157	1367
<i>Төлөвлөгөөт бус сургалт</i>	36	528
<b>Нийт</b>	<b>193</b>	<b>1895</b>

#### Зорилтот бүлгээр авч үзвэл:

Зорилтот бүлэг	Цаг	Оролцогч
<i>Хууль хяналтын байгууллагын албан хаагчдад</i>	26	429
<i>Төрийн захиргааны, үйлчилгээний байгууллагын албан хаагчдад</i>	85	932
<i>ХХЕГ-ын ажилтан, алба хаагчдад</i>	62	453
<i>Өмгөөлөгч, сэтгүүлч, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлд</i>	19	69
<i>Оюутан залуучуудад</i>	1	12
<b>Нийт</b>	<b>193</b>	<b>1895</b>

#### 2.1.2 "Бизнес ба хүний эрх" сургалтын загвар хөтөлбөр боловсруулах

2013 оны 9 дүгээр сард Данийн Хүний эрхийн хүрээлэн, Фридрих Эбертийн сантай хамтран зохион байгуулах “Бизнес ба хүний эрх” сургалтад оролцогчид болон Комиссын ажилтнуудаас бүрдсэн “Бизнес ба Хүний эрх” сургалтын загвар хөтөлбөр, гарын авлага боловсруулах ажлын хэсгийг байгуулж, гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн. Сургалтыг зохион байгуулах талаар Данийн хүний эрхийн хүрээлэнтэй холбогдон мэдээлэл солилцон ажиллаж байна.

### *2.1.3 Хүний эрхийн цахим сургалт зохион байгуулах*

Комиссоос хүний эрхийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг өргөжүүлэх, орон зайн хамаарлыг даван туулах, сургалт зохион байгуулах шинэ арга замыг эрэлхийлэх зорилгоор ХЭҮК-ын цахим кампуст ([www.nhrctm.org](http://www.nhrctm.org)) "Хүний эрхийн мониторинг" сэдэвт туршилтын сургалтыг 5 сарын 29-нөөс 6 сарын 26-ны өдөр хүртэл сайн дураар хүсэлтээ илэрхийлсэн 33 оролцогчдод зохион байгууллаа.

### *2.1.4 Хорих ангийн ажилтнуудад бүсчилсэн сургалт зохион байгуулах,*

2013 оны эхний хагаст Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон-Уул, Хөвсгөл, Булган, Архангай, Баянхонгор, Говь-Алтай аймгуудад зохион байгуулсан "Хүний эрхийн нээлттэй өдөр" арга хэмжээний хүрээнд төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад "Төрийн үйлчилгээн дэх хүний эрхэд суурилсан хандлага", хууль сахиулах байгууллагын ажилтнуудад "Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хангах нь" сэдвээр сургалт зохион байгуулсан бөгөөд нийт 429 албан хаагчид оролцсон.

### *2.1.5 Хүний эрхийн зуны сургалт зохион байгуулах*

2013 оны 7 дугаар сарын 1-5 ны өдрүүдэд оюутан залуучуудад зориулсан Хүний эрхийн зуны сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд их, дээд сургуулиудад эмч, багш, орчуулагч, эрх зүйч, сэтгүүлч, олон нийттэй харилцах, түүх нийгэм, улс төр, сэтгэл судлал, статистик, нийгмийн хангамж, халамж зэрэг мэргэжилээр суралцаж байгаа 24 оюутан залуус хамрагдсан байна. Сургалтыг оролцооны аргад тулгуурлан, бүлгийн ажилд идэвхтэй оролцуулж, асуулт хариулт ярилцлага хэлэлцүүлэг явуулах замаар дүгнэлт хийлгэх хэлбэр явууллаа.

Сургалт хүний эрхийн зарчмууд, хүний эрхийн зөрчил, төрийн хүлээх үүрэг, хүний эрхийн хязгаарлалт, хариуцлага, хүний эрхийг хамгаалахад тулгардаг бэрхшээл, жендэрийн тэгш эрхийн байдал, мэдэх эрх, мэдээлэл авах талаар, хувийн нууцын тухай, хүний эрхийн соёл гэж юу вэ, хүний эрхийн боловсрол, сонгох сонгогдох эрхийн талаар, иргэний нийгэм тэдний нийгэм дэх оролцоо, манлайлал, гэх мэт сэдвүүдийн хүрээнд явагдсан. Сургалтанд оролцогчид Комиссын дэргэд залуусын дуу хоолой болж ажиллах хүний эрхийн бүлгэм, клуб байгуулан ажиллах санал санаачлагыг гаргасан байна.

### *2.1.6 Байгууллагуудын хүсэлт, захиалгаар хүний эрхийн сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулах*

ХХЕГ-тай байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хилийн ангиуд болон заставын ажилтан, алба хаагчдад зориулсан сургалтыг явуулж байна. 2013 оны эхний 6 сарын байдлаар ХХЕГ-ын харьяа 0101, 0243, 0257, 0163, 0108, 0129, 0214 дүгээр анги тус бүр дээр "Хүний эрхийн үндсэн ойлголт", "Хүний эрхэд суурилсан хандлага", "Гэр бүлийн хүчирхийллийн асуудлууд", "Хувь хүний харилцаа,

ээрэг сэтгэлгээ, өсөлт хөгжил” сэдвүүдээр нэг өдрийн буюу нийт 62 цагийн сургалтыг хийсэн. Сургалтад ХХЕГ-ын 7 анги нэгтгэлийн 453 алба хаагчид оролцсон.

## **2.2 Хүний эрхийн сурталчилгаа:**

### *2.2.1 “Хүний эрхийн нээлттэй өдөр” арга хэмжээг 3 чиглэлд бүсчилэн зохион байгуулах*

Хүний эрхийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, Комиссын үйл ажиллагааг сурталчилах зорилгоор 3-6 дугаар сард Дархан-уул, Сэлэнгэ, Орхон, Архангай, Булган, Баянхонгор, Говь-Алтай аймгуудад “Хүний эрх нээлттэй өдөр” арга хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд төрийн албан хаагчийн хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор төр захиргаа, хууль хяналтын байгууллагын 890 гаруй ажилтан, албан хаагч нарыг хамруулсан нийт 112 цагийн сургалтыг зохион явуулж, тухайн аймгуудын цагдан хорих, урьдчилан хорих байруудад тус тус хяналт шалгалтыг зохион байгуулж холбогдох шаардлага зөвлөмжийг хүргүүлсэн. Мөн ажлын хүрээнд нийт 160 гаруй иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлтэй уулзалт ярилцлага хийж, давхардсан тоогоор нийт 91 иргэнд хуулийн зөвлөгөө өгч, өргөдөл гомдлыг хүлээн авч ажилласан байна.

### *2.2.3 Бизнесийн байгууллагуудад чиглэсэн хүний эрхийн сурталчилгааны цогц үйл ажиллагаа хийх*

Хүний эрхийн Үндэсний Комиссын бизнесийн байгууллагад чиглэсэн нөлөөллийн ажлын стратегийн баримт бичгийн эхний төслийг боловсруулж, Данийн хүний эрхийн хүрээлэнтэй хамтран 9 дүгээр сард зохион байгуулах “Бизнес ба хүний эрх” сургалтын үеэр хэлэлцүүлэн оролцогчдын саналыг тусган бизнесийн байгууллагууд чиглэсэн сургалт, сурталчилгааны нэгдсэн стратеги боловсруулах, стратеги дээрээ үндэслэн сургалт, сурталчилгааны цогц үйл ажиллагаа явуулах гэсэн шатлалтайгаар үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж байна.

Эхний хагас жилийн хугацаанд Фридрих Эбертийн сантай хамтран Данийн хүний эрхийн хүрээлэнтэй холбоо тогтоох, сургагч багш урих, сургалтын хөтөлбөр агуулгыг ярилцах ажлууд хийсэн.

### *2.2.5 Сэтгүүлчдийн клубын үйл ажиллагааг өргөжүүлэх*

Комиссын дэргэд “Хүний эрхийн төлөө сэтгүүлчид” клубыг 11 гишүүнтэйгээр 2012 онд байгуулан ажиллуулж эхэлсэн бөгөөд энэ оноос гишүүдийн тоог 4-өөр нэмэгдүүлж, клубын үйл ажиллагааг өргөжүүлэх, идэвхжүүлэх, хүний эрхийн мэргэшсэн сэтгүүлч бэлтгэх бодлого барин ажиллав. Клуб нь сар тутам уулзалт зохион байгуулж, хүний эрхийн анхаарал татсан асуудлаар аян зохиож, нийтлэл, нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтийн хүртээл болгосоор байна. 2013 оны эхний хагас жилийн байдлаар 63 орчим нийтлэл, нэвтрүүлэг, мэдээ мэдээлэл бэлтгэн хүргээд байна.

МҮОНРТ-тэй байгуулсан хамтран ажиллах Санамж бичгийн хүрээнд бэлтгэн хүргэж буй хүний эрхийн анхны нэвтрүүлэг болох “Хүний эрх, миний эрх”

нэвтрүүлгийг МҮОНТВ-ийн Уран бүтээлийн 1-р нэгдэлтэй хамтран 2013 онд “Хүний эрх”, “Хилс хэрэгт шийтгүүлсэн хүмүүсийн хохирлыг нөхөн төлүүлэх”, “Эрх нь зөрчигдсөн хүн хаана хандах вэ”, “Иргэдийн мэдэх эрх”, “Ажлын байран дахь бэлгийн дарамт”, Эмэгтэйчүүдийн хорих ангиас бэлтгэсэн сурвалжлага нийт 6 дугаарыг бэлтгэн хүргэлээ.

#### *2.2.6 Хүний эрхийн сэдвээр олон нийтийн цуврал лекцийг үргэлжлүүлэн зохион байгуулах*

Хүний эрхийн сэдвээр олон нийтийн цуврал лекц зохион байгуулах төлөвлөгөөний дагуу 2013 оны 3 дугаар сарын 28-ны өдөр 15 цагт **“Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ ба өвчтөний эрх”** сэдвээр ЭМШУИС-ийн АУС-ийн Ерөнхий Мэргэжил Урьдчилан Сэргийлэх Анагаахын Тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны доктор, профессор Д.Одонтуяа Нээлттэй нийгэм форумын хурлын танхимд илтгэл тавьсан.

Лекцийн талаарх зарыг Эрүүл мэндийн яам, Хавдар судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв болон 9 дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, анагаах ухааны чиглэлээр сургалт явуулдаг 7 их, дээд сургуулиудад албан бичгээр, иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээ болон комиссын цахим хуудас фэйсбоок, твитер ашиглан түгээж ажилласан. Албан бичгээр хүргүүлсэн зар мэдээллийн дагуу 5 байгууллагаас 87 хүн оролцох хүсэлтээ ирүүлсэн боловч илтгэл хэлэлцүүлэгт 57 хүн оролцсон.

Хоёр дахь удаагийн лекцийг 2013 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр 15 цагт МУИС-ын дугуй танхимд зохион байгуулсан бөгөөд **“Улс төрийн эрх, эрх чөлөө- Сонгох, сонгогдох эрх”** сэдвээр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Сургалтын албаны зөвлөх багш, ХБНГУ-ын Бонн хотын их сургуулийн төр, эрх зүйн тэнхимийн докторант Д.Үүрцайх илтгэл тавьсан.

Лекцийн талаарх зар мэдээллийг хууль зүй, нийгмийн ухаан, улс төрийн чиглэлээр сургалт явуулдаг 22 их, дээд сургууль, коллежид албан бичгээр, иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээ болон комиссын цахим хуудас фэйсбоок, твитерээр түгээж ажилласан. Албан бичгээр хүргүүлсэн зар мэдээллийн дагуу 8 сургуулиас 170 багш, оюутан оролцуулахаар нэрс болон тоог ирүүлсэн боловч 117 хүн оролцсон байна.

Гурав дахь удаагийн лекцид **“Европ дахь хэвлэлийн эрх чөлөө ба иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрхийн асуудал”** сэдвээр Европын комиссын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудлаарх дээд хэмжээний мэргэжилтнүүдийн ажлын хэсгийн гишүүн, Берлиний Чөлөөт Их сургуулийн профессор, олон улсын хүний эрхийн зөвлөх Херта Даублер Гмелин 2013 оны 5 дугаар сарын 29-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хуульчдын танхимд илтгэл тавьсан.

Лекц зохион байгуулах ажлын хүрээнд сэтгүүл зүйн чиглэлээр сургалт явуулдаг 18 их, дээд сургууль, коллежид албан бичгээр, иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээ болон комиссын цахим хуудас фэйсбоок, твитерээр

түгээсэн хэдий ч лекцид 45 хүн оролцож илтгэгчээс сонирхсон асуудлаар асуулт, хариулт авлаа.

### *2.2.7 "Хүний эрх" сэтгүүл хэвлүүлэх*

2013 оны 1 дугаарыг эрүүдэн шүүхтэй холбоотой асуудлаар дагнан бэлтгэж, гадаад, дотоодын судлаач, эрдэмтдийн өгүүлэл, нийтлэлээс бүрдсэн. Сэтгүүлийг 500 хувь хэвлэж Хууль зүйн яам, УИХ зэрэг байгууллагуудад тараан нөлөөллийн үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд хэрэглэж байна.

Мөн Хүний эрх сэтгүүлийн редакцийн зөвлөлийг Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 10 дугаар тушаалаар шинэчлэн байгууллаа.

### *2.2.8 Өдөр тутмын зарим сонинд хүний эрхийн булан ажиллуулах*

Өдөр тутмын сонин мэдээлэл бэлтгэх ажлын төлөвлөгөө, тавигдах шаардлага, үнэлгээний хуудас боловсруулан мөрдөж ажилласны үр дүнд сонины мэдээлэл тогтмол цаг хугацаандаа чанартай бэлтгэгдэн нийтдээ 25 нийтлэлийг Үндэсний шуудан, Зууны мэдээ сонинуудад нийтлүүлээд байна. Түүнчлэн эдгээр нийтлэлүүдийг комиссын цахим хуудсанд Таны мэдлэгт буланд сонирхсон хүмүүс татаж авах боломжтойгоор байруулсан.

### *2.2.11 Нийтийн тээврийн хэрэгслийн дэлгэцээр хүний эрхийг сурталчлах*

Улаанбаатар хотын нийтийн тээврийн 20 чиглэлд 190 ширхэг автобусанд байрлах дэлгэцээр сард 6 төрлийн хүний эрхийн асуудлаарх шторк, рекламьг өдрийн 48 удаагийн давтамжтайгаар цацуулж байна. Сар бүр автобусны дэлгэцээр цацагдаж буй сурталчилгааны хөтөлбөрийг авч, хяналт тавьж, илэрсэн зөрчлийн талаар тухай бүр нь Содон суваг телевизийн захирал Д.Отгонбаатарт мэдээллэж зөрчлийг арилгуулан ажиллаж байна.

### *2.2.12 Комиссын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах*

2013 оны эхний хагас жилийн байдлаар ХЭҮК-ын үйл ажиллагаа, эрүү шүүлт, ажлын байран дахь бэлгийн дарамт, хүүхдийн эрх, мэдэх эрх, ялтны эрх, жендэр ба хүний эрх зэрэг сэдвээр Комиссын дарга, гишүүд, Ажлын албаны ажилтнууд нийт МҮОНТВ, Монгол, Ийгл, UBS, ТВ5, ТВ9 зэрэг 20 телевиз, Өдрийн сонин, Өнөөдөр, Зууны мэдээ, Үндэсний шуудан зэрэг өдөр тутмын 11 сонин, МҮОНР, Гэр бүлийн радио 105.5, Шинэ зуун радио зэрэг 5 радиод нийт 352 удаа ярилцлага, тодруулга мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өгсөн байна.

Комиссын захиалгаар ETV телевизийн сурвалжлах баг Орхон аймагт ажиллаж, эрх нь зөрчигдсөн иргэн Д.Ням-Очирын тухай баримтат нэвтрүүлэг бэлтгэн олон нийтийн хүртээл болгов. Үндэстний цөөнх цаатан иргэдийн амьдрал ахуй, нөхцөл байдлыг сурвалжилсан баримтат нэвтрүүлгийг Хөвсгөл аймгийн Цагааннуур, Улаан-Уул сумдаас МҮОНТВ-ийн ММ агентлагтай хамтран бэлтгэлээ.

## 2.2.9 Комиссын цахим хуудсанд шинэ мэдээлэл тогтмол оруулах, боловсронгуй болгон сайжруулах

Комиссын цахим хуудаст шинэ мэдээлэл тогтмол оруулах, боловсронгуй болгон сайжруулах төлөвлөгөө гарган ажиллаж, сайтын нүүр хэсэг болон системын тохиргоог шинэчлэн сайжруулах ажлыг бүрэн хийж дуусгалаа. ХЭҮК-ээс захиалан хийлгүүлсэн бүх нэвтрүүлэг, шторк, хүний эрхийн хичээл, хүний эрхийн илтгэл хэлэлцүүлгийн дүрс бичлэгийг цахим хуудаснаа оруулав. Мөн үйл ажиллагааны чиглэл тус бүрээр мэдээллийг хэлтэс тус бүрээс бэлтгэн баяжуулсан мэдээллийг оруулав. Эхний хагас жилийн байдлаар нийт 86 орчим хэвлэлийн мэдээ, мэдээлэл бэлтгэн оруулж, 120 гаруй гэрэл зураг болон дүрс бичлэгийг шинээр нэмж байршууллаа.

Комиссын цахим хуудаст “Гомдол гаргах нь” шинээр цэс үүсгэн англи, монгол хувилбараар иргэдээс гомдол хүлээн авах боломжийг бүрдүүллээ. Түүнчлэн өдөр тутмын гэрээт сонинуудад нийтэлсэн хүний эрхийн цуврал хичээлийг Комиссын цахим хуудаснаа “Таны мэдлэгт” булан үүсгэн байршуулж байна.

## 2.2.10 Хүний эрхийн мэдээллийн хуудсыг хэвлүүлж, түгээх

Комиссын үйл ажиллагааг сурталчлах, хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор улирал тутам эрхлэн гаргадаг “Хүний эрхийн мэдээллийн хуудас”-ын 2 дугаарыг нийт 1300 ширхэгийг хэвлүүлж, Сэлэнгэ, Орхон, Хөвсгөл, Баянхонгор, Говь-Алтай аймгийн иргэд, орон нутгийн удирдлагуудад түгээв.

## 2.2.11 Ном, товхимол хэвлүүлэх ажлын хүрээнд

Эхний хагас жилийн байдлаар 11 төрлийн 15600 ширхэг сурталчилгааны материалыг хэвлүүлсэн. Үүнд:

	<b>Хэвлүүлсэн ном, товхимол</b>	<b>Тоо, ширхэг</b>
1	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл /монгол/	1500
2	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл /англи/	300
3	Дэвтэр	2000
4	Цаасан тор	500
5	Комиссын танилцуулга	500
6	Стратеги төлөвлөгөө	300
<b>Эвхмэл хуудасны нэр</b>		
1	ХЭҮК	2500
2	Хүний эрх гэж юу вэ	2500
3	ХЭҮК-т өргөдөл, гомдол гаргах нь	1500
4	АББД	2000
5	Хүний эрх ба төрийн үүрэг	2000

## **ГУРАВ. ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА БОЛОН КОМИССЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

### **3.1. Гадаад хамтын ажиллагаа**

*3.1.1 Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Олон улсын зохицуулах хорооны ээлжит хуралд Комиссын төлөөлөл оролцох*

Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын Олон Улсын Зохицуулах Хорооны 26 дугаар хуралд ХЭҮК-ын дарга Ж.Бямбадорж оролцлоо. Хурлаар хүний эрхийн үндэсний байгууллагуудын хамтын ажиллагааны ойрын ирээдүй, НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын асуудлаарх Тусгай илтгэгчийн илтгэл, 2012 оны Амманы Тунхаглалын мөрөөр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, оролцооны эрх зэрэг асуудлыг хэлэлцсэн. Тус хурлын үеэр Комиссын дарга Австрали, БНСУ-ын болон бусад Хүний эрхийн үндэсний байгууллагуудын удирдлагуудтай уулзаж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

*3.1.2 АНДХЭҮБЧ-ны АА-ны дарга нарын хурал, Австралийн ХЭК-т туршлага судлах хөтөлбөрт төлөөлөл оролцуулах*

Ази Номхон Далайн бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын ажлын албаны дарга нарын уулзалт болон Австралийн Хүний эрхийн Комисс дээр туршлага солилцох хөтөлбөрт 2013 оны 6 дугаар сарын 24-28 ны өдрүүдэд Ази Номхон Далайн бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын чуулганы санхүүгийн дэмжлэгтэйгээр ХЭҮК-оос Ажлын албаны даргын хамт хоёр ажилтан оролцсон.

Австралийн Хүний эрхийн үндэсний Комиссын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаатай танилцах ажлын хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн асуудал хариуцсан баг, Насаар ялгаварлан гадуурхахын эсрэг баг, Бэлгийн чиг баримжаа ба хүйсийн илэрхийллийн асуудал хариуцсан баг, Харилцааны асуудал хариуцсан баг, Нийгмийн шударга ёс асуудал хариуцсан баг, Хүйсээр ялгаварлан гадуурхахын эсрэг баг, Олон нийттэй харилцах баг, Мөрдөн шалгалт ба эвлэрүүлэн зуучлах баг, Хяналт шалгалт ба үнэлгээний баг, Хуулийн баг, Хүүхдийн эрхийн асуудал хариуцсан баг, Хүний эрхийн баг, Арьс өнгөөр ялгаварлан гадуурхахын эсрэг хариуцсан багуудтай уулзаж, харилцан туршлага солилцлоо. Түүнчлэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын чиг үүрэг, сүүлийн жилүүдэд явуулсан үйл ажиллагааны талаар Австралийн Хүний эрхийн Комиссын хамт олонд танилцуулга хийв. Цаашид Комиссын гомдол шийдвэрлэх ажиллагаа, бодлогын дүн шинжилгээ хийх, хууль тогтоомжийг хүний эрхийн үүднээс үнэлэх, дүгнэх зэрэг Австралын Хүний эрхийн Комиссын туршлагыг нэвтрүүлэх, тус Комисстой бусад асуудлаар харилцан хамтран ажиллахаар санал солилцож туршлага судалсан үр дүнтэй хөтөлбөр боллоо.

*Хүний эрхийн ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн талаар НҮБХХ-өөс зохион байгуулах сургалтад Комиссын төлөөллийг оролцуулах*



### *3.1.3 НҮБ-ын гэрээний хороод, тусгай илтгэгч, ажлын хэсгүүд, ХЭДКГ-тай хамтран ажиллах*

Хүний эрхийн ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн талаар НҮБХХ-өөс зохион байгуулах сургалтад 2013 оны 6 дугаар сард Ажлын албаны дарга Г.Золжаргал, референт Т.Ихтамир нар оролцож, харилцан мэдээлэл, туршлага солилцов.

### *3.1.5 Финландын Хүний эрхийн Холбоо, Данийн Хүний эрхийн Хүрээлэнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх*

Данийн Хүний эрхийн Хүрээлэнтэй холбоо тогтоосны үндсэн дээр тус хүрээлэнгээс 2 сургагч багш 9 дүгээр сард Монгол Улсад хүрэлцэн ирж, ХЭҮК-ын ажилтнууд болон хүний эрхийн чиглэлээр ажилладаг бусад төрийн бус байгууллагуудын төлөөллийн оролцуулан “Бизнес ба хүний эрх” сэдэвт сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна.

### *3.1.6 Европын аюулгүй байдал ба хамтын ажиллагааны албатай хамтын ажиллагаа эхлүүлэх*

ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн газартай уулзаж, хамтран ажиллах санал хүсэлт тавьсны үндсэн дээр тус газраас 2-3 сургагч багш Монгол Улсад 10 сард хүрэлцэн ирж, ХЭҮК-ын ажилтнуудад зориулсан “Жендэрийн эрх тэгш байдал ба хүний эрхийн мониторинг” сэдэвт сургалтыг явуулахаар төлөвлөж байна.

### *3.1.7 Шинэ Зеландын Хөгжлийн байгууллагад төслийн санал боловсруулж, хүргүүлэх*

Комисс нь “Орон нутагт хүрч ажиллах чиглэлээр хүний эрхийн дэмжих бүлэг байгуулах нь” төслийн саналыг Шинэ Зеландын Засгийн газарт хүргүүлсний дагуу тэтгэлэгт хамрагдаж, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний идэвх санаачлагад тулгуурласан хүний эрхийн дэмжих бүлгийг байгууллаа. Тус дэмжих бүлэг нь орон нутагт дахь хүний эрхийн төлөв байдлыг тодорхойлох, цаашид орон нутгийн түвшинд хамтын ажиллагааг өргөжүүлэх, улмаар сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах хэлбэрээр иргэдийг чадавхжуулах, алслагдмал газарт хүрч ажиллах зэргээр Комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

Түүнчлэн дараах хоёр төслийн саналыг тус тус хүргүүлээд байна. Үүнд:

- Орон нутаг дахь иргэний нийгмийн байгууллагуудын хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголт, хандлагыг үнэлэх, чадавхжуулах чиглээр Канад сангаас зарласан төслийн уралдаанд;
- Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын холбогдох хороодоос Монгол улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийн эмхтгэлийн 1,2-р ботиудыг хэвлүүлэх санхүүжилт хайх зорилгоор Ардчиллалын төлөөх Тайваны Санд.

### *3.1.8 Олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлэх*

2013 оны эхний хагас жилийн байдлаар ХЭҮК-т дараах гадны зочид төлөөлөгчид хүрэлцэн ирж, Комиссын дарга, гишүүдтэй уулзалт хийж, цаашдын хамтын ажиллагааны чиглэлээр санал солилцсон байна. Үүнд:

- Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын олон улсын хөдөлмөрийн стандарт, хөдөлмөрийн хуулийн ахлах мэргэжилтэн ноён Тим Дэ Мээр
- Бүгд Найрамдах Финлянд Улсын Хууль зүйн сайд хатагтай Анна Маяа Хенриксон, тус улсаас БНХАУ-д суугаа Элчин сайд ноён Ларс Бакштром нарын тэргүүтэй төлөөлөгчид
- ЕАБХАБ-ын илтгэгчдийн багтай уулзалт
- ХБНГУ-ын Бундестагийн Өргөдлийн байнгын хорооны гишүүд,
- ЕАБХАБ-ын Ардчилсан институт, Хүний эрхийн Газрын Захирал Янез Ленаршиш
- ЕАБХАБ-ын Ардчилсан институт, Хүний эрхийн газрын Элчин сайд болон хуулийн зөвлөх
- НҮБ-ын Хүүхдийн Сангийн Зүүн Ази болон Номхон Далайн бүсийн Хүүхэд хамгаалалын бүсийн зөвлөх болон хүүхэд хамгаалалын шинжээч
- БНХАУ-д Бээжинд суугаа Шинэ Зеландын Элчин Сайдын Яамны эдийн засгийн асуудал хариуцсан зөвлөх
- Хүний эрхийн боловсролыг бүрэн дунд боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх, хөхиүлэн дэмжих, хамтран ажиллах зорилго бүхий ХЭҮК болон Фор Ди Груп /FourD Group/, ХЭҮК болон Хүний эрхийн төлөөх залуус /Youth four Human Rights/ хооронд байгуулах Санамж бичгийн төсөл эцэслэгдэж талууд гарын үсэг зурахад бэлэн боллоо.

### *3.1.9 Австралийн Хөгжлийн байгууллагын сайн дурын ажилтанг ажиллуулах*

“Хөгжлийн төлөөх Австралийн залуу элчин сайд” буюу Австралийн Засгийн Газрын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан Эми Рожерсийг ХЭҮК-д Боловсрол хариуцсан сайн дурын ажилтнаар 1 жилийн хугацаатайгаар энэ оны 3 дугаар сараас эхлэн ажиллуулж байна. Тэрбээр ХЭҮК-ын зохион байгуулж буй олон улсын чиг хандлагатай сургалт, уулзалтыг зохион байгуулахад бичиг баримт боловсруулах, дотоодын сургалт явуулах, англи хэл дээрх албан бичгийг хянах, шаардлагатай судалгааг хийхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

## **3.2. Дотоод хамтын ажиллагаа**

### *3.2.1 Орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх*

Эхний хагас жилийн байдлаар Орон тооны бус зөвлөлийн хурлыг 2013 оны 3 дугаар сарын 13, 6 дугаар сарын 17-ны өдрүүдэд зохион байгуулаад байна.

2013 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн хурлаар Комиссын шинээр томилогдсон гишүүн Н.Ганбаярыг танилцуулах, Комиссын 2013 оны үйл ажиллагааны төлөвлөө болон 2013 оны 1 дүгээр улиралд хийсэн ажлын тайланг хэлэлцсэн болно. Тус хуралдаан Комиссын дарга, гишүүд болон орон тооны бус зөвлөлийн 16 гишүүн

оролцсон. Хурлаар хэлэлцсэн асуудал болон хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг гишүүдэд цахим шуудангаар хүргүүлсэн болно.

6 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар Комиссын эхний хагас жилд хийсэн үйл ажиллагааны тайлан болон орон тооны бус зөвлөлийн гишүүн байгууллагуудаас явуулж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг сонссон болно. Хуралд орон тооны бус зөвлөлийн 21 гишүүнээс 7 гишүүн оролцсон.

### *3.2.2 "Хүний эрхийн Үндэсний Комисс, иргэний нийгмийн түншлэл" ээлжит уулзалтыг тодорхой сэдвүүдээр зохион байгуулах*

"НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн "Хүний эрхийн төлөв байдлын талаарх ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR)-ээс Монгол Улсын Засгийн газарт хандсан зөвлөмжийн хэрэгжилт, дунд хугацааны тайлагналт" сэдэвт ХЭҮК болон иргэний нийгмийн байгууллагуудтай зөвлөлдөх 6 дахь уулзалтыг 2013 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Хүний эрхийн Үндэсний Комисс, Засгийн газрын холбогдох яамд, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Нээлттэй нийгэм Форум хамтран зохион байгуулав.

Энэхүү уулзалт нь төр, иргэний нийгмийн байгууллагуудтай мэдээлэл солилцож зөвлөлдсөнөөрөө онцлог байсан юм. Уулзалтад 40 гаруй төрийн бус байгууллагын төлөөлөл, нийт 80 орчим хүн оролцсон юм. Тус арга хэмжээний үеэр Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 159 тоот тогтоолын хэрэгжилт, "Хүний эрхийн төлөв байдлын талаарх ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг"-ийн (UPR) зөвлөмжийн хэрэгжилтийн дунд хугацааны тайлагналт, UPR Info-д Монгол Улсаас илгээсэн тайлан мэдээлэл, цаашид анхаарах асуудлуудын талаар мэдээлэл солилцов.

### *3.2.3 Хүний эрхийн чиглэлээр ажиллаж буй иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх жижиг тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх*

Энэ ажил 2013 оны сүүлийн хагас жилд хийхээр төлөвлөгдсөн болно.

### *3.2.4 Төрийн байгууллагуудтай байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд үйл ажиллагаа явуулах*

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоотой 2011 онд байгуулсан хамтран ажиллах "Санамж бичиг"-ийн хүрээнд 2013 оны 1 дүгээр сарын 15-нд "Хөдөлмөрлөх эрхийн төлөв байдал" сэдэвт хамтын ажиллагааны уулзалтыг хийж, барилгын салбарт ажиллагсдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийхээр төлөвлөж, бэлтгэл ажлыг хангаж байна.

Олон улсын хүний эрхийн зарим гэрээг соёрхон батлах буюу түүнд нэгдэн орох чиглэлээр шийдвэр гаргагчдад болон холбогдох яамдад дараах саналуудыг хүргүүлээд байна.

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хороонд хүүхдийн эрхийн зөрчлийн талаар хүүхэд өөрөө буюу түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигч гомдол гаргах боломжийг хангасан Хүүхдийн эрхийн тухай конвенцийн гуравдугаар Нэмэлт Протоколыг соёрхон батлах;

2. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг бий болгох зорилгоор Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколд нэгдэн орох;
3. Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх зорилгоор “Байгаль орчны асуудлаар мэдээлэл олж авах, шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог хангах тухай” конвенц (Аархусын конвенц)-д нэгдэн орох;
4. Уул уурхайн салбарт ажиллагсдын ажлын аюулгүй байрыг бий болгох асуудлаарх Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын “Уул уурхайн үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” 176 дугаар конвенцид нэгдэн орох;

#### *4.1.2 Комиссын ажилтнуудыг чадавхижуулах дотоод сургалт зохион байгуулах*

2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр “Олон улсын хөдөлмөрийн байгууллагын хөдөлмөрийн үндсэн суурь зарчим, хэм хэмжээ, хөдөлмөрлөх эрхийн ойлголт” сэдвээр ОУХБ-ын олон улсын хөдөлмөрийн стандарт, хөдөлмөрийн хуулийн ахлах мэргэжилтэн ноён Тим Дэ Мээр,

2013 оны 5 дугаар сарын 2-ны өдөр “Хууль тогтоомж, олон улсын гэрээний заалтыг ашиглахад анхаарах зарим зүйл”, “Хууль зүйн зөвлөгөө өгөхөд анхаарах асуудал”, болон “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх” сэдвээр Комиссын дарга Ж.Бямбадорж, Гомдол, хяналт шалгалт, бодлогын дүн шинжилгээний хэлтэс болон сайн дурын ажилтан Ами Рожерс нар удирдан явуулсан. Дээрх сургалтад Комиссын Ажлын албаны ажилтнууд оролцов.

#### *4.1.3 Хүний эрхийн олон улсын сургалт, магистрын хөтөлбөрт ажилтнуудаа хамруулах*

Референт Б.Болорсайхан нь ШХУ-ын Женев дэх НҮБ-ын ХЭДКГ-ын Үндэсний байгууллагууд ба бүсийн механизмийн хэлтэс дээр 6 сарын дадлага хийх ХЭҮБ-уудын ажилтнуудад зориулсан тэтгэлэг хөтөлбөрт хамруулах ажлыг зохион байгуулав. Б.Болорсайхан нь 2013 оны 8 дүгээр сарын 1-нээс 2014 оны 2 дугаар сарын 1-ний өдөр хүртэл дадлагажигчаар ажиллаар болсон.

Референт Б.Нандинцэцэг нь Энэтхэгийн Засгийн Газрын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдан Энэтхэг улсын Дели хотод 2013 оны 8 дугаар сарын 23-ны өдрөөс 2013 оны 10 дугаар сарын 17-ны өдөр хүртэл 2 сарын хугацаатай англи хэлний сургалтад оролцох боллоо.

## **МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН АЖЛЫН АЛБА**

**2013.07.10**